



МОНГОЛ УЛСЫН  
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2017 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Сонгуулийн Ерөнхий Хорооноос ТОГТООХ нь:

1. “Улс төрийн нам, төрийн бус байгууллагаас ард нийтийн санал асуулгын талаар ухуулга сурталчилгаа хийх журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Ухуулагчийн товч анкет”-ыг 2 дугаар хавсралт, “Ухуулагчийн үнэмлэхний загвар”-ыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

ДАРГА Ч.СОДНОМЦЭРЭН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Ц.БОЛДСАЙХАН



Сонгуулийн Ерөнхий Хорооны  
2017 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн  
17... дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**УЛС ТӨРИЙН НАМ, ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААС  
АРД НИЙТИЙН САНАЛ АСУУЛГЫН ТАЛААР  
УХУУЛГА СУРТАЛЧИЛГАА ХИЙХ ТУХАЙ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Улс төрийн нам, төрийн бус байгууллагаас ард нийтийн санал асуулга /цаашид “санал асуулга” гэх/-ын талаар ухуулга сурталчилгаа хийхтэй холбогдох харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Улсын Дээд шүүхэд бүртгэлтэй улс төрийн нам болон төрийн бус байгууллага энэхүү журамд заасны дагуу бүртгүүлж, өөрийн зардлаар санал асуулгаар тавигдаж байгаа асуудлыг нийтэд таниулах, мэдээллээр хангах хэлбэрээр ухуулга сурталчилгаа явуулж болно.

1.3. Ухуулга сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, интернет орчин ашиглан явуулж болно. Мөн сум, хороонд нэг ухуулагч томилон ажиллуулж болно.

**Хоёр. Ухуулга сурталчилгаа явуулах  
эрх бүхий этгээдийг бүртгэж, үнэмлэх олгох**

2.1. Ухуулга сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд нь ухуулга сурталчилгаа явуулах тухай хүсэлтээ дараах баримт бичгийн хамт санал авах өдрөөс долоогоос доошгүй хоногийн өмнө Сонгуулийн Ерөнхий Хороонд ирүүлнэ.

2.1.1. улсын бүртгэлийн гэрчилгээ;

2.1.2. хуулийн этгээдийн дүрэм;

2.1.3. ухуулга сурталчилгаа явуулах үйл ажиллагааны төлөвлөгөө;

2.1.4. ухуулагч томилсон шийдвэр. /хэрэв ухуулагч ажиллуулах бол/

2.2. Ухуулга сурталчилгаа хийх нам, төрийн бус байгууллагыг Сонгуулийн Ерөнхий Хороо бүртгэнэ.

2.3. Сонгуулийн Ерөнхий Хороо нь энэ журмын 2.1.4-т заасан баримт бичгийг аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд хүргүүлнэ. Ухуулагчаар ажиллах этгээд нь ухуулагчийн анкетийг бөглөж аймаг, нийслэлийн сонгуулийн хороо /санал асуулгыг дангаар явуулж буй тохиолдолд аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар/-нд хүргүүлнэ.

2.4. Ухуулагчийг аймаг, нийслэлийн сонгуулийн хороо /санал асуулгыг дангаар явуулж буй тохиолдолд аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар/ бүртгэж, үнэмлэх олгоно.

**Гурав. Ухуулга сурталчилгаа явуулах  
эрх бүхий этгээдийн эрх, үүрэг**

3.1. Ухуулга сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд нь энэ журмын 1.3-т заасны дагуу үйл ажиллагаа явуулна.

3.2. Ухуулга сурталчилгаа явуулахдаа санал асуулгад оролцохгүй байхыг уриалах, эсхүл аливаа улс төрийн нам, эвсэл, хамтарсан нам, нэр дэвшигчийн талаар сурталчилгаа явуулахыг тус тус хориглоно.

## **Дөрөв. Хариуцлага**

4.1. Ард нийтийн санал асуулгын тухай хууль, Сонгуулийн тухай хууль болон Монгол Улсын бусад хууль тогтоомж, энэ журамд заасныг зөрчсөн ажиглагчид хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

---оо---

Сонгуулийн Ерөнхий Хорооны  
2017 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн  
17... дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**УХУУЛАГЧИЙН ТОВЧ АНКЕТ**

3 x 4  
зураг

20... оны ... дугаар сарын ...-ны өдөр

1	Овог, эцэг /эх/-ийн нэр	
2	Нэр	
3	Нас, хүйс	
4	Иргэний харьяалал	
5	Одоо эрхэлж буй ажил, албан тушаал	
6	Мэргэжил	
7	Төлөөлж буй нам, төрийн бус байгууллагын нэр	
8	Харилцах хаяг, утас	

**АНКЕТ БИЧСЭН:**

/...../

Сонгуулийн Ерөнхий Хорооны  
2017 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн  
17... дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

УХУУЛАГЧИЙН ҮНЭМЛЭХ


АРД НИЙТИЙН САНАЛ АСУУЛГА



УХУУЛАГЧИЙН ҮНЭМЛЭХ

Нүүр тал

Дугаар ...




.....ЫГ  
.....нам/ТББ-аас  
томилогдсон ухуулагчаар бүртгэж,  
ҮНЭМЛЭХ ОЛГОВ.

..... аймаг/нийслэлийн сонгуулийн  
хорооны дарга ..... / /

... оны ... сарын ...-ны өдрийг хүртэл хүчинтэй

Ар тал A

**Дугаар ...**



.....ыг  
.....нам/ТББ-аас  
томилогдсон ухуулагчаар бүртгэж,  
үнэмлэх олгов.

..... аймаг/нийслэлийн ЗДТГ-ын  
дарга ..... / /

... оны ... сарын ...-ны өдрийг хүртэл хүчинтэй

**Ар тал Б**